



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.МӨНХБАТ ТАНАА

2023.03.15 № 07/557
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу Гүйцэтгэх захирлын 2021 оны А/89 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг, 2022 оны 2 дугаар сарын 18-ний өдөр ажилтан, ажил олгогч 2 талын харилцан хэлэлцээрээр Хамтын гэрээг тус тус шинэчлэн баталсан байна.

Тус компани нь ТӨБЗГ-ын 2022 оны 307 дугаар тогтоолоор 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас Ирээдүйн өв санд төвлөрүүлэхээр тогтоосон 478.0 сая төгрөгийн хувьцааны ногдол ашгийг шилжүүлж, санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 23-ны 637 дугаар тогтоолоор Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2022 оны эдийн засгийн үзүүлэлтүүд, зорилтод түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 56,702.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 55,296.9 сая төгрөгөөр төлөвлөж, 1,100.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар баталсан.

Гүйцэтгэлээр 60,036.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 57,103.4 сая төгрөгийн зардал гарган, 2,356.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Z:\Yawsan_Bichig\2023\03\15 SNAG-52.Docx

0001951021

Бусад асуудлын хэсэг

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь 2022 онд техник шинэчлэл хөрөнгө оруулалтын 8 багц арга хэмжээнд 11,767.2 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдснаас 8,567.2 сая төгрөгийн худалдан авалтын тендер зарлаж, 52 харилцагч байгууллагатай 6,971.8 сая төгрөгийн гэрээ хийж баталгаажуулсан байна.

Тус компанийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

